



Г АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014 . 05 . 23 № 1/811.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Чиглэл өгөх тухай**

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийн дагуу 1990-2000 онуудад тасарсан ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулахаар хуульд заасан баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлсэн боловч баталгаажилтын хуудас авсан болон аваагүй байхдаа нас барсан иргэний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлд заасан болзол нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоон олгоно.

2. Харин тухайн иргэн нас барснаас хойш хугацаанд түүний гэр бүлийн болон бусад холбогдох этгээд “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийн дагуу тухайн нас барсан иргэний 1990-2000 онуудад тасарсан ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулахаар бүртгүүлж, ажилласан жилийг нөхөн тооцуулсан бол үүнийг хүчингүйд тооцно.

Дээрх чиглэлийг хэрэгжүүлэхдээ тухайн иргэний нас барсны гэрчилгээнд бичигдсэн нас барсан огноог, иргэд (даатгуулагч)-аас гаргасан ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах өргөдлийн огноо болон нөхөн даатгалын бүртгэлийн програмын огноотой тулган шалгаж, шийдвэрлэж ажиллах нь зүйтэй.

ДАРГА



Ц.УРТНАСАН